



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 6/03

Хэрлэн сум

Ардын дуу бүжгийн Хан Хэнтий Чуулгын
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын шинэ барилга ашиглалтад орж, MNS6476:2014 стандартын дагуу орон тоо нэмэгдэх шаардлагатай болсон тул бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан бүтэц орон тооны дагуу ажлын байрыг оновчтой тогтоон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловчруулан баталж, гэрээ байгуулж, хэвийн үйл ажиллагаагаар хангаж ажиллахыг Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга (Д.Цогт-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 07-ны А/438 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ